НҮБ-ЫН ХҮН АМЫН САН
МОНГОЛ УЛС

ЖИРЭМСЛЭЛТ БҮР ХҮССЭН, ТӨРӨЛТ БҮР ЭСЭН МЭНД, ЗАЛУУ ХҮН БҮР НӨӨЦ БОЛОЛЦООГОО БҮРЭН ДАЙЧИЛЖ, ХӨГЖЛИЙН ӨНДӨРЛӨГТ ХҮРЭХ НӨХЦӨЛИЙГ БҮРДҮҮЛЭХИЙН ТӨЛӨӨ.

УЛИРАЛ ТУТМЫН МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ №21 (5) – 2022 ОНЫ 7-9-Р САР

‘БИ ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВД ЦААШДАА ҮРГЭЛЖЛҮҮЛЭН АЖИЛЛАХ ЧИН ХҮСЭЛТЭЙ БАЙГАА’

Залуучуудын хөгжлийн төв нь НҮБ-ын Хүн амын сангийн залуучуудын хөгжлийг дэмжих чухал суваг юм. НҮБ-ын Хүн амын сангаас 2013-2017 онд амжилттай туршсаны эцэст эдгээр төвүүдийг Засгийн газрын мэдэлд шилжүүлсэн.
НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газраас залуучуудад амьдрах ухааныг эзэмшүүлэх, Монголын ирээдүйг чиглүүлэгч, манлайлагч болох чадавхиа бэхжүүлхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх зорилгоор Залуучуудын хөгжлийн төвүүдийг ажиллуулдаг юм.
Залуучуудын хөгжлийн төвийн ачаар хувийн болон мэргэжлийн ажил үйлсээрээ хэрхэн өсч хөгжсөн талаараа тус төвөөр үйлчлүүлж бас тус төвд ажиллаж байгаа хоёр залуус бидэнтэй хуваалцлаа.

Сайн байна уу, намайг Баяраагийн Улаанаа гэдэг. Өмнөговь аймгийн Цогтцэций суманд аавынхаа хамт амьдардаг.
2015 онд 10 жилийн сургуулиа төгсөөд 2015 оноос эхлэн Цогтцэций сумын Залуучуудын хөгжлийн төвд ажилласан.
Өмнө нь би хүмүүстэй ярилцахдаа муу өөрийгөө илэрхийлж чаддаггүй, багаар ажиллаж чаддаггүй байсан. Залуучуудын хөгжлийн төвд ажилд орсноор өөрийгөө нээж, хөгжүүлж бусдад өөрийгөө илэрхийлж, бусдыг манлайлж ажиллах чадвартай болсон.
Би Залуучуудын хөгжлийн төвд цаашдаа үргэлжлүүлэн ажиллах чинь хүсэлтэй байгаа. Яагаад гэвэл өөрийгөө илүү хөгжүүлэх, бусдад болон манай Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлж байгаа хүүхэд залуучуудад мэдээ, мэдээлэл хүргэж ажиллах хүсэлтэй байгаа.
Залуучуудын хөгжлийн төв төрийн болон төрийн бус байгууллагуудтай уялдаа холбоо сайтай ажилласнаар залууст илүү ойр ажиллах боломжтой болно гэж боддог. Дараагийн асуудал гэвэл залууст тулгамдаж байгаа асуудлыг сумын удирдлагуудад хүргэснээр хэрэгжүүлэх, ажил хэрэг болгох боломжтой гэж хардаг.

ЭНЭ ДУГААРТ

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ
3-Р ХУУДАС

БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНД БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРХ
5-Р ХУУДАС

ӨСВӨР ҮЕ БА ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖИЛ
7-Р ХУУДАС

МОНГОЛ УЛСЫН 21 АЙМГИЙН СУМ БҮРД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВҮҮД ШИНЭЭР БАЙГУУЛАГДАЖ ЗАЛУУЧУУД ТУС ТӨВӨӨР ДАМЖУУЛАН ХӨГЖИЖ ЧАДВАЛ ЗАЛУУ ХҮН БҮР ЭЕРЭГ НИЙГЭМ, ЭЕРЭГ ИРЭЭДҮЙГ БҮТЭЭХ БОЛНО ГЭДЭГТ ИТГЭДЭГ'



Миний нэрийг Цоодол овогтой Нэрзул гэдэг. Өмнөговь аймгийн Ханбогд суманд нөхөр охиныхоо хамт амьдардаг.

Анх 2018 онд энэ суманд гэр бүлээрээ шилжиж ирээд 2019 онд Өмнөговь аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын харъяа Ханбогд сумын Залуучуудын хөгжлийн төвөөс төрийн байгууллагад ажиллах ажлын гараагаа эхлэн 3 дахь жилдээ ажиллаж байна.

Анх Залуучуудын хөгжлийн төвийнхөө Оролцоо хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байгаад одоогоор Залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна . Би хятад хэлний багш мэргэжилтэй, Гэр бүл судлалын магистрын зэрэгтэй, Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох мэргэшсэн зөвлөх. Залуучуудын хөгжлийн төвд ажилладагтаа маш их бахархдаг, хийсэн бүтээсэн ажлуудаасаа их урам зориг эрч хүчийг авдаг. Залуучуудын хөгжлийн төв миний хувь хүний хөгжил болон миний амьдралд маш олон боломжуудыг нээж эерэг өөрчлөлт дэвшилтүүдийг бий болгосон. Тухайлбал Залуучуудын хөгжлийн төвөөрөө дамжуулан нийгмийн оролцоогоо сайжруулж, залуучуудыг манлайлан тэднийгээ дэмжих залуучуудтайгаа хамран ажиллах, тэднийхээ дуу хоолойг хүргэх гүүр нь болж өөртөө илүү итгэлтэй, илүү их хариуцлагыг өөртөө бий болгож, нийгэмдээ илүү их зүйлийг хийж бүтээх урам зоригийг авсан. Ингэснээрээ нийгэмд эзлэх байр суурьа тодорхой болгож хувь хүний хөгжил талаасаа маш их зүйлийг суралцаж, туршлага хуримтлуулж, өөрийгөө дайчилж, шинийг санаачилж хөгжиж чадсан.

Залуучуудын хөгжлийн төвөөс залуучуудад үзүүлдэг амьдрах ухааны сургалт, клуб, дэмжих бүлгийн үйл ажиллагаа, зөвлөлийн үйл ажиллагаа, холбон зуучлах үйлчилгээ, сэтгэлзүйн зөвлөгөө, мэргэжил сонголтын зөвөлгөө зэрэг бүхий л үйлчилгээ үйл ажиллагаанд гар бие оролцдог.

Нэг талаараа суралцаж нөгөө талаараа туршлага хуримтлуулж тасралтгүй хөгжиж байдаг болохоор хувийн амьдралд минь тохиолдох аливаа асуудал сорилтыг даван туулахад илүү дөхөм болсноос гадна өөрийн гэр бүл төдийгүй ах эгч хамаатан садныхаа гэр бүлд ч сурсан мэдсэн туршлагаасаа хуваалцан тулгараад буй асуудлыг эерэгээр шийдвэрлэхэд нь нөлөөлж чадах болсон.

Залуучуудын хөгжлийн төвөөс үзүүлдэг эдгээр үйлчилгээнд хамрагдсан үр шим хүртэгчид нь эргээд гэр бүл найз нөхөд хамаатан садан болон танилын хүрээндээ эерэгээр нөлөөлөх бүрэн боломжтой байдаг. Монгол улсын 21 аймгийн сум бүрд Залуучуудын хөгжлийн төвүүд шинээр байгуулагдаж залуучууд тус төвөөр дамжуулан хөгжиж чадвал залуу хүн бүр эерэг нийгэм, эерэг ирээдүйг бүтээх болно гэдэгт итгэдэг.

Залуучуудын хөгжлийн төвийн үр шимийг улам их нэмэгдүүлэхийн тулд юуны өмнө төвд ажилладаг албан хаагчдын орон тоог нэмэгдүүлэх, тэдний ажил амьдралын баталгааг бий болгох нь нэн тэргүүний асуудал юм. Залуучуудын хөгжлийн төв нь 15-34 насны залуучуудын эрхийг хангаж хөгжүүлэхээс гадна залуучуудтай холбоотой нийгмийн бүхий л асуудалтай тулж ажилладаг тул 2-3 албан хаагчийн орон тоо нь тухайн орон нутгийнхаа бүх залуучуудад үр шимийг нь бүрэн хүртээх боломжгүй юм. Ингэснээрээ залуучууд ажлаасаа хашрах, ажилдаа дургүй болох, цалин хөлсөө голох, ажлын байраа орхих нь элбэг тохиолддог. Хэдийгээр Залуучуудын хөгжлийн төвд ажиллаж буй залуучууд маш олон чиглэлээр сургагч, багшаар бэлтгэгдэн, сурч боловсорч хөгжиж чаддаг ч ажлын ачаалал, цалин хөлсний асуудлаас болж ажлын байраа орхиж буй нь үнэхээр харамсалтай. Ингээд дахиад л шинэ албан хаагчдыг чадавхжуулах хэрэгтэй болдог энэ нь цаг хугацааны хувьд ч, үр шим хүртээх үр дүнгийн хувьд ч маш ихээр сөргөөр нөлөөлдөг.

ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИД ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙГ УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ТУРШЛАГАА СОЛИЛЦЛОО

Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг Нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ), Түр хамгаалах байрны (ТХБ) жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйлчилгээ үзүүлэгчдийн дунд дотоодын туршлага судлах аяллыг Дархан-Уул, Хөвсгөл аймгуудад 2022 оны 8-р сарын 4-10-ны хооронд зохион байгуулаа.

Энэхүү үйл ажиллагаа нь нэгэн зорилгын төлөө, нэг салбарт ажиллаж байгаа үйлчилгээ үзүүлэгчдэд Монголын нөхцөлд туршигдаад үр дүнтэй нь батлагдсан сайн туршлагаа хуваалцах, бие биеэсээ суралцах, тулгарч буй бэрхшээл асуудлаа ярилцах, тэдгээрийн гарц шийдлийг хэлэлцэх боломжийг олгодог. Тиймээс ч эндээс гарсан зөвлөмж, сургамж нь танхимаар ордог сургалт семинарыг бодвол өдөр тутмын үйл ажиллагаандаа шууд хэрэгжүүлэх боломжтой байдгаараа онцлогтой. Мөн НЦҮТ, ТХБ-ны ажилчид хоорондоо танилцаж, цаашдаа мэдээлэл туршлагаа солилцож байх боломжийг олгодог.

Энэхүү ажлыг Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй хэрэгжиж буй “Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн 2-р шатны хүрээнд зохион байгуулсан бөгөөд нийт 50 үйлчилгээ үзүүлэгчид оролцож Дархан-Уул, Хөвсгөл, Завхан аймгуудын сайн туршлагаас сонсож суралцсан юм.

Сайн туршлагуудаас гадна eGBV, eTuslamj зэрэг тоон мэдээллийн сангуудын тухай, нэмэлтээр жендэр, жендэрийн тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийллийн талаарх ойлголт, бэлгийн мөлжлөг, хүчирхийллээс сэргийлэх тухай, хамтарсан багийн үйл ажиллагаанд хийсэн хяналт үнэлгээнээс гарсан гол дүгнэлтүүд, хамтарсан багтай хамтран ажиллах, холбон зуучлах зураглалын талаар, мөн стресс менежментийн талаар танилцуулгуудыг холбогдох мэргэжилтнүүд хийсэн билээ.

НИЙГМИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ АВЧРАХ ЦОГЦ АРГАЧЛАЛЫГ ТАНИЛЦУУЛЛАА

Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилттэй хэрэгжиж буй “Монгол улсад жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх нь” төслийн 2-р шатны хүрээнд олон нийтэд суурилсан зан үйл өөрчлөх цогц загварыг боловсруулж, турших төслийн уралдааныг 2021 оны 9 дүгээр сард зарласан билээ.

Пипл ин Нийд Монгол, Монфемнет үндэсний сүлжээ, Эрчүүд, эрүүл гэр бүл гэсэн 3 төрийн бус байгууллагын нэгдлийн санал шалгарч Сургуульд суурилсан, Олон нийтэд суурилсан, Хэвлэл мэдээлэлд суурилсан 3 хэсэг бүхий Нийгэм-Зан үйлийг өөрчлөх цогц загварыг боловсруулан юм.

Төслөө 2021 оны 9 сараас 2022 оны 9 сар хүртэл хэрэгжүүлсэн бөгөөд энэ хугацаанд боловсруулсан загвараа төслийн сонгогдсон 2 газар болох Архангай аймаг, Баянзүрх дүүрэгт туршсан юм. 2022 оны 9 сарын 27-ны өдөр боловсруулсан цогц загвараа, туршилтаас гарсан үр дүнгийн хамт НҮБ-ын жендэрийн багийн гишүүд болон НҮБ-ын Хүн амын сангийн хэрэгжүүлэгч байгууллагуудын төлөөллүүдэд танхимаар, 9 сарын 28-ны өдөр төслийн бусад сонгогдсон аймгууд, 21 аймаг, 9 дүүргийн жендэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд, мөн иргэний нийгмийн байгууллагуудад цахимаар тус тус 150 гаруй хүнд танилцуулаа.

ХҮМҮҮНЛЭГИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ АВАХ ХӨТӨЛБӨРТ САРЫН ТЭМДГИЙН ЭРҮҮЛ МЭНД, ЭРҮҮЛ АХУЙН АСУУДЛЫГ ТУСГАХ НЬ

Үндэсний онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд, НҮБ-ын Хүн амын сан Онцгой байдлын ерөнхий газрын (ОБЕГ) алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг дэмжин ажиллаж ирсэн билээ. 2022 оны 8 сарын 26-ны өдөр ОБЕГ-ын 30 гаруй эмч, эмнэлгийн зааварлагч нарт НҮБ-ын Хүн амын сангийн Ази, номхон далайн бүсийн мэргэжилтэн сарын тэмдгийн эрүүл мэнд, эрүүл ахуйн асуудлыг онцгой байдал, хүмүүнлэгийн хөтөлбөрт тусгахын ач холбогдлын талаар танилцуулах хичээлийг орлоо.

Учир нь дэлхийн хэмжээнд 26 сая гаруй дүрвэгч охид эмэгтэйчүүд нөхөн үржихүйн насан дээрээ буюу сарын тэмдэг нь ирсэн байдаг ч сарын тэмдгийн асуудал, түүнтэй холбоотой эрүүл мэнд, эрүүл ахуйн асуудлыг тэр бүр нээлттэй ярьдаггүй учир үнэн зөв мэдлэг мэдээлэл, сарын тэмдэг гэж юу болох сарын тэмдгийн эрүүл ахуйг сахихад хэрхэх талаарх мэдээлэл дутмаг байдаг. Онцгой байдлын үед охид эмэгтэйчүүд хувийн орон зай үгүй болж, аюулгүй байдал нь эрсдэлд ордог тул сарын тэмдгээ зохицуулахад илүү саад бэрхшээл тулгардаг.

Цаашлаад, нөөц боломж хомс нөхцөлд сарын тэмдгийн асуудлаа зохицуулах нь бүр ч илүү хүнд болдог бөгөөд тухайн улс орны нийгэм, соёлын онцлог нь энэ асуудлыг улам хүндрүүлэх шалтгаан болдог. Энэ бүх асуудлууд нийлээд хүмүүнлэгийн үйлчилгээг сарын тэмдэг нь ирж байгаа хүн бүрд хүргэхэд саад учруулж байдаг.

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГИЙН ҮЕЭР ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫН АСУУДАЛ АНХААРЛЫН ТӨВД БАЙЛАА

Тогтвортой хөгжлийн зорилт, тогтвортой хөгжлийн асуудлын талаар олон нийтэд нөлөөлж, сурталчлан таниулах, мөн түүнд хүрэхэд олон нийтийг татан оролцуулах, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготойгоор "Тогтвортой хөгжлийн зорилт" нээлттэй өдөрлөгийг 2022 оны 9 сарын 10-ны өдөр Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага хамтрагч байгууллагуудтайгаа хамтран Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.

Энэ өдөр НҮБ-ын Хүн амын сан бусад НҮБ-ын төрөлжсөн агентлагуудтай хамтран Тогтвортой хөгжлийн 5-р зорилт буюу Жендэрийн тэгш байдлыг хангах зорилтыг сурталчлан таниулах, олон нийтэд мэдлэг түгээх үйл ажиллагааг амжилттай удирдан зохион байгууллаа. Энэ үеэр олон нийтийг шууд оролцуулж, хамруулах төрөл бүрийн үйл ажиллагааг явуулж байсан бөгөөд жендэрт суурилсан хүчирхийлэл, түүний хор уршгийн талаар мэдлэг, мэдээллийг түгээж ажилласан юм.

Түүнчлэн НҮБ-ын Хүн амын сан нь гэр бүл төлөвлөлтийн орчин үеийн аргуудыг сурталчлах, эхийн амь насыг аврах үр дүнтэй арга хэмжээнүүдийн талаарх мэдээ, мэдээллийг ард иргэдэд түгээх, улмаар бэлгийн цогц боловсрол олгох, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх замаар Тогтвортой хөгжлийн 3, 4-р зорилт болох Чанартай боловсролыг дэмжих болон Эрүүл мэндийг дэмжих зорилтуудад хүрэхийн тулд олон нийтийн оролцоо, дэмжлэгийг сайжруулах хэрэгцээг таниулахад хамтран ажиллаа.

ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДАЛ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРЧИМЖҮҮЛЭХ НҮБ-ЫН СИСТЕМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭ

НҮБ-ын Хүн амын сангийн Жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийг чадавхжуулах хөтөлбөрийн мэргэжилтэн НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгууллагаас Ази номхон далайн бүс нутгийн орнуудын дунд энэ оны 3-р улиралд зохион байгуулсан семинарт оролцлоо. Семинарын үеэр НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын жендэрийн үйл ажиллагааг үнэлэх үнэлгээний үзүүлэлтүүд болон түүний дагуу хийх ажлын нэгдсэн төлөвлөгөөг хийх аргазүйг танилцуулсан юм.

ЭХ, НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНДЭД СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖ БУЙ ХАЛДВАРЫГ ЭРТ ИЛРҮҮЛЭХ ЗОРИЛГООР 3 ЛАБОРАТОРИ БАЙГУУЛЛАА

Монгол улсын Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээг дэмжиж Люксембургийн Засгийн газар болон НҮБ Хүн амын сангийн хамтран хэрэгжүүлж буй “Цар тахлын үед эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах нь” төслийн хүрээнд Улаанбаатар хотын Өргөө, Амгалан амаржих газрууд, Яармаг дахь Эх, нярай, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн үндэсний төвд молекул биологийн иж бүрэн тоноглогдсон гурван лаборатори байгуулж ашиглалтад оруулллаа.

Байгуулагдсан лабораториуд нь зөвхөн Ковид-19 халдвараас гадна нөхөн үржихүйн замын халдварууд, умайн хүзүүний хавдрын үүсгэгчийг илрүүлэх урвалж бодис, технологийн хамт нийлүүлэгдсэн болно. Ингэснээр эмэгтэйчүүдийн халдварын илрүүлэг оношилгоо сайжирч, улмаар умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийг бууруулахад дэмжлэг болох юм.

ЖИРЭМСЭН БОЛОН ХӨХҮҮЛ ЭХЧҮҮДИЙГ КОВИД-19-ИЙН ЭСРЭГ ВАКЦИНЖУУЛАЛТАД ХАМРАГДАХЫГ УРИАЛЛАА

Өнөөдрийн байдлаар Ковид-19-ийн нас баралт буурсан ч жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийг Ковид-19-ийн эсрэг вакцинжуулалтад тасралтгүй хамрагдуулах шаардлагатай байна. Иймд жирэмсэн болон хөхүүл эмэгтэйчүүдийг Ковид-19-ийн эсрэг вакцинжуулахын ач холбогдлыг дэмжсэн богино хэмжээний видео мэдээллийг TB25, Боловсрол зэрэг телевизүүд, олон нийтийн сүлжээгээр түгээлээ.

ЛЮКСЕМБУРГ, НҮБ-ЫН ХҮН АМЫН САН МОНГОЛ УЛСАД ЭХ, НЯРАЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ХАМТЫН АЖИЛЛАГААГАА ӨРГӨЖҮҮЛЭВ

2022 оны 7 дугаар сарын 29-ний өдөр Люксембургийн Хөгжлийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн асуудал болон Эдийн засгийн сайд ноён Франц Файот, Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн, доктор Халид Шарифи нар Төслийн санхүүжилтийн гэрээнд гарын үсэг зурав.

Гэрээний дагуу Люксембургийн Их Гүнт Улсаас 2022-2027 он хүртэл 5 жилийн хугацаанд 5 сая еврогийн буцалгүй тусламж үзүүлэх юм. Өмнөх 12 жилийн хугацаанд хэрэгжсэн "Эх, нярайн эрүүл мэндийн зайн оношилгоонд дэмжлэг үзүүлэх" төслийн туршлага дээр тулгуурлан хэрэгжих шинэ төсөл нь технологийн дэвшлийг ашиглан гэр бүл төлөвлөлт, жендэрт суурилсан хүчирхийлэл, гэр бүл төлөвлөлт, бэлгийн цогц боловсролыг дэмжих замаар сэргийлэх боломжтой эхийн эндэгдлийг тэглэхэд хувь нэмэр оруулах болно.

Люксембургийн Хөгжлийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн асуудал хариуцсан сайд ноён Франц Файот тэргүүтэй Люксембургийн Засгийн газрын төлөөлөгчид, Эрүүл мэндийн яам, Шастины нэрэмжит Улсын 3-р эмнэлэг, бусад төрийн албаны төлөөлөгчид, Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүн, доктор Халид Шарифи нарын хамтарсан баг Хөвсгөл аймагт ажиллалаа.

Төлөөлөгчид Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэйгээр тус аймагт эх, нярайн эрүүл мэнд, зүрх судасны эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагааны хэрэгжилттэй танилцаж, орон нутгийн эрүүл мэндийн салбарт аймаг, сумдын түвшинд тулгамдаж буй асуудлуудаар санал солилцлоо.

ЭХ БАРИХЫН ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖИЙН СУРГАЛТЫГ ХҮРГЭЛЭЭ

Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвөөс эх барихын яаралтай тусламжийн үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг есдүгээр сарын 7-8-ны өдрүүдэд зохион байгууллаа. Люксембургийн Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй “Монгол Улсад Ковид-19 цар тахлын үед эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах нь” төслийн хүрээнд зохион байгуулагдсан энэхүү хоёр өдрийн сургалтад 18 эмч сургагч багшаар бэлтгэлээ. Цаашид төлөвлөсөн хуваарийн дагуу Нийслэлийн түргэн тусламжийн төв, амаржих газрууд, хөдөө орон нутгийн үйлчилгээ үзүүлэгчид энэ сургалтад үе, шаттайгаар хамрагдах болно.

ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ҮНЭЛЭВ

НҮБ-ын Хүн амын сангаас Эрүүл мэндийн салбарын жендэрт суурилсан хүчирхийллийн хариу арга хэмжээний бэлэн байдлын үнэлгээг санаачлан эхлүүлээд байна. Үнэлгээнээс гарах үр дүнгээс гэр бүлийн хүчирхийлэл болон хамтран амьдрагчийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод үйлчлүүлэгч төвтэй, эрхэд суурилсан үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, байгууллагуудын чадавхыг сайжруулах дараагийн алхмуудыг боловсруулахад шаардлагатай үйл ажиллагааны хүрээ тодорхой болно.

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН САРААР ҮЕ ҮЕИЙН ЭВ НЭГДЛИЙГ ДЭМЖЛЭЭ

Энэ жилийн Олон улсын залуучуудын өдөр “Үе хоорондын эв санааны нэгдэл: Бүх насныханд ээлтэй ертөнцийг бий болгох нь” сэдвийн дор зохион байгуулагдаж байна. Тус өдрийг тохиолдуулан Залуучуудын хөгжлийн үндэсний сарын аяныг 8-р сарын 12-ны өдөр албан ёсоор эхлүүлж, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр нээлтийн арга хэмжээг зохион байгууллаа.

Нээлтийн үеэр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас сарын аяны хүрээнд хийхээр төлөвлөсөн үйл ажиллагаанууд, тэдгээрээс хүлээгдэж буй үр дүнг танилцуулж, залуучуудыг тус үйл ажиллагаануудад идэвхтэй оролцохыг урианлаа. Нээлтийн арга хэмжээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, НҮБ-ын Суурин зохицуулагч ноён Тапан Мишра, Монгол дахь НҮБ-ын Хүн амын сангийн Тэргүүн Др. Халид Шарифи, залуучууд, залуучуудын хөгжлийн асуудлаарх оролцогч талуудын төлөөлөл оролцов.

Олон улсын залуучуудын өдрийн энэ жилийн сэдвийн хүрээнд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, нийгэм, эдийн засгийн хөгжилд оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх замаар бүх насныханд ээлтэй дэлхий ертөнцийг бий болгоход залуучуудын оролцоо чухал болохыг оролцогч талууд онцолж байлаа.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд тулгарч буй сорил, шийдэл, арга замыг залуучуудтай хамтран хэлэлцэх, шийдэл, зөвлөмжийг Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлөөр албажуулах, бодит үр дүнд хүрэх зорилготой “Залуучуудын хөгжлийн үндэсний цахим чуулган”-ыг “Хүртээмжит нийгэм: Залуучуудын оролцоо-Хөдөлмөр эрхлэлт” сэдвийн хүрээнд 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр цахимаар зохион байгууллаа.

Чуулганд төр, иргэний нийгэм, олон улсын байгууллагууд, аймаг, нийслэл, дүүргийн нийт 600 гаруй төлөөлөгч цахимаар, 1700 гаруй залуучууд, олон нийт цахимаар оролцлоо. Үндэсний чуулганыг Засгийн газрын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дэд тэргүүн А.Ариунзаяа, Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагч Тапан Мишра, Монгол Улс дахь НҮБ-ын Хүн амын сангийн Тэргүүн Др.Халид Шарифи нар нээж залуучуудад мэндчилгээ дэвшүүлсэн.

Үндэсний чуулганыг угтсан дэд хэлэлцүүлгийг улс даяар 8 дугаар сарын 17-ны өдөр бүх аймаг, дүүрэгт зохион байгуулж, нийт 2700 гаруй залуучууд оролцож залуучуудын хөдөлмөр эрхлэлт, хөгжил, оролцоог дэмжихэд салбарын яамд, орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагууд, холбоод, залуучуудын иргэний нийгмийн байгууллагууд, залуучуудын оролцоо, хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн 700 гаруй санал санаачилгыг үндэсний чуулганд ирүүлсэн.

Чуулган болон салбар хэлэлцүүлгийн үеэр залуучуудаас гаргасан санал, зөвлөмжийг нэгтгэн, Монгол Улсын Засгийн газар болон бусад оролцогч талуудад хүргүүлэхээр болов. Эдгээр санал, зөвлөмжийг Ерөнхий сайдаар ахлуулсан Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, албажуулах юм.

ХОРИХ ТӨВИЙН ЗАЛУУЧУУДАД АМЬДРАХ УХААНЫ БОЛОВСРОЛ, БЭЛГИЙН БОЛОН НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН МЭДЛЭГИЙГ ОЛГОХ ХӨТӨЛБӨРИЙГ ДЭМЖИВ

НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) нь цагдан хорих төвүүдэд амьдрах ухааны боловсрол, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн агуулгыг багтаасан "Хоригдлыг суллахад бэлтгэх" цогц хөтөлбөрийг боловсруулаа. Тус хөтөлбөр нь хорих ангиас суллагдсан залуучуудыг нийгэмд гарахад бэлтгэх, шинэ орчинд дасан зохицоход бэлтгэх, хорих газраас суллагдсан залуучуудын эмзэг байдлыг бууруулж, шинэ орчны үр өгөөжийг хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилготой юм. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн хамтарсан тушаалаар тус хөтөлбөрийг баталсан бөгөөд цаашид НҮБ-ын Хүн амын сангаас цагдан хорих төвд ажиллаж буй нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг чадавхжуулах үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ СУРГУУЛИУДАД ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ КАБИНЕТ БАЙГУУЛАГДЛАА

Тусгай хэрэгцээт 29 ба 116-р сургуулиудад Эрүүл мэндийн хичээлийн кабинетыг НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр байгуулж, үйл ажиллагааг 9 сарын 23-ны өдөр нээлээ. Нээлтийн арга хэмжээнд Боловсрол шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүн амын сан, сургуулиудын удирдлага, багш, сурагчдын төлөөлөл оролцлоо.
Эрүүл мэндийн хичээлийн кабинетыг байгуулснаар багш нар эрүүл мэндийн хичээлийг үр өгөөжтэй, оролцоонд түшиглэн чанартай заах сургалтын орчин бүрдэж, сурагчид эрүүл мэнд, бэлгийн цогц боловсролыг чанартай эзэмших боломжтой болох юм.

"ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН АЖИЛТАН" АЖИЛ МЭРГЭЖЛИЙГ ШИНЭЭР БҮРТГЭЛЭЭ

Залуучуудыг, ялангуяа хөдөө орон нутгийн хөгжлөөс гадуур орхигдсон залуучуудыг чадавхжуулах нь НҮБ-ын Хүн амын сангийн тэргүүлэх чиглэлүүдийн нэг юм. Энэхүү хүчин чармайлтын хүрээнд НҮБ-ын Хүн амын сан үндэсний хэмжээнд залуучуудын хөгжлийн тогтолцоог анхан шатны төвшинд бэхжүүлэхэд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-ыг дэмжин ажиллаж байна.
Тэгвэл НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр ХНХЯ-ын тушаалаар Залуучуудын хөгжлийн төвийн "Залуучуудын хөгжлийн ажилтан" ажил мэргэжлийг нийгмийн ажилтны ангилалд шинээр бүртгэлээ. Цаашид ХНХЯ НҮБ-ын Хүн амын сантай хамтран шинээр бүртгэгдсэн ажил мэргэжлийн стандарт шаардлагыг багтаасан Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааны жишиг журмыг боловсруулах юм. Энэхүү стандартууд нь үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Залуучуудын хөгжлийн төвүүдийн үйл ажиллагаа, үйлчилгээний жишиг болж, залуучуудад үзүүлж буй үйлчилгээний хамрах хүрээ, чанарыг хангах юм.

НОТОЛГООНД СУУРИЛСАН ТӨЛӨВЛӨЛТ, БОДЛОГО БОЛОВСРУУЛАХ ЗОРИЛГООР ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙГ ЦУГЛУУЛАХ АЖЛЫГ ДЭМЖИВ

НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам (ХНХЯ) энэ онд Залуучуудын хөгжлийн төвүүдийн анхан шатны мэдээлэл цуглуулах болон хуваарьт мэдээлэл нэгтгэх маягтуудыг сайжруулан, шинэчиллээ. Үндэсний хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Залуучуудын хөгжлийн төвүүд маягтуудыг өдөр тутмынхаа үйл ажиллагаанд ашиглан, төвөөр үйлчлүүлэгч залуучуудын талаарх анхан шатны тоон мэдээллийг цуглуулж, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ), ХНХЯ зэрэг холбогдох байгууллагуудад хуваарийн дагуу нэгтгэн хүргүүлснээр нотолгоонд суурилсан төлөвлөлт хийж, бодлого боловсруулах нөхцөл бүрдэж байна.

Анхан шатны мэдээлэл цуглуулах маягт болон хуваарьт мэдээлэл нэгтгэх маягтуудыг Үндэсний статистикийн хорооноос 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр, маягт бөглөх зааврыг 2022 оны 9 дүгээр сарын 8-ны өдөр ГБХЗХГ-ын даргын тушаалаар тус тус баталсан.

ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДЭД ЗОРИУЛСАН ЦАХИМ ЧАДАВХЫГ БЭХЖҮҮЛЭХ ЦУВРАЛ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА

НҮБ-ын Хүн амын сан НҮБ-ын Залуучуудын ажлын хэсгийг 2022 онд ахалж байгаа ба Залуучуудын хөгжлийн төв (ЗХТ)-ийн ажилтнуудыг бусад НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай хамтран чадавхжуулах жилийн төлөвлөгөө боловсруулсан. Төлөвлөгөө ёсоор Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн сан зэрэг НҮБ-ын хэд хэдэн агентлаг 2022 онд ЗХТ-ийн ажилтнуудад цахим сургалт явуулахаар төлөвлөж байна. Сургалтын гол зорилго нь ЗХТ-ийн ажилтнуудад олон талт, орчин үеийн мэдлэг, мэдээлэл олгох замаар залуучуудад хүргэх үйлчилгээний чанарыг сайжруулах юм.

Энэ хүрээнд 2022 оны 9 сарын 16-ны өдөр Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагатай хамтран хүн худалдаалах гэмт хэргийн талаар мэдлэг олгох, эх орондоо эргэн суурьших хөтөлбөрийн талаар мэдээлэл өгөх сургалтыг цахимаар зохион байгуулаа.

Сургалтад аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар болон Залуучуудын хөгжлийн төвийн 38 албан хаагчид оролцлоо.

Мөн 2022 оны 9 сарын 23-ны өдөр НҮБ-ын Хүн амын сангаас гэр бүл төлөвлөлт, түүний ач холбогдлын талаар мэдээлэл өгөх сургалтыг цахимаар зохион байгуулсан ба сургалтад аймаг, нийслэлийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар болон Залуучуудын хөгжлийн төвийн 30 албан хаагчид оролцлоо.

ТАЛАРХАЛ

Жирэмслэлт бүр хүссэн, төрөлт бүр эсэн мэнд, залуу хүн бүр нөөц бололцоогоо бүрэн дайчилж, хөгжлийн өндөрлөгт хүрэх нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө хүчин чармайлтыг үргэлж дэмждэг хандивлагчид, түншүүд, үр шим хүртэгчиддээ баярлалаа.

Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

LUXEMBOURG AID & DEVELOPMENT

JOINT SDG FUND

UNITEL

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Н.Гэндэнжамцын нэрэмжит ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

POLICE

МОНГОЛ УЛСАД ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГА

UNITED NATIONS MONGOLIA

ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛ:

Б. Хаш-Эрдэнэ
Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн ажилтан

Имэйл: bayarsaikhan@unfpa.org

Visit us at mongolia.unfpa.org

www.facebook.com/UNFPA.Mongolia

twitter.com/UNFPA_Mongolia

www.instagram.com/unfpa_mongolia/